



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/273

Хэрлэн сум

Үзэсгэлэнд оролцоход
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах өдөрлөгийн арга хэмжээнд оролцоход шаардагдах зардалд зориулж 296,000 (хоёр зуун ерэн зургаан мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 27-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардал	Хэмжих нэгж	Мөнгөн дүн
1	Стенд	2ш	96,000
2	Бензин	78 литр	200,000
	нийт		296,000